

БАТЛАВ."ХААБ" ХХК  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:  
...../Х.БААТАР /

БАТЛАВ. ....ХХК  
ЗАХИРАЛ:  
.....

## ТЭЭВРИЙН ИТГЭМЖЛЭЛИЙН ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

20... оны ... -р сарын ... өдөр

№ ....

Улаанбаатар хот

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Энэхүү гэрээг “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль”, “Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам”, “Тээвэрлэгчийн итгэмжлэл олгох журам” болон бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийн хүрээнд нэг талаас “Хөдөө аж ахуйн бирж” ХХК (цаашид “Бирж” гэх)-ийг төлөөлж Төлбөр Тооцоо, Ложистикийн Хэлтсийн захирал ....., нөгөө талаас “\_\_\_\_\_” ХХК (цаашид “Итгэмжлэгдсэн тээвэрлэгч” гэх)-ийг төлөөлж \_\_\_\_\_ албан тушаалтай, \_\_\_\_\_ регистрийн дугаартай, \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_ нар харилцан тохиролцож байгуулав.
- 1.2 Энэхүү гэрээний зорилго нь Хөдөө аж ахуйн бирж”-ээр арилжаалагдсан бараа, түүхий эд /цаашид “ачаа” гэх/-ийг Монгол улсын нутаг дэвсгэрт болон улс хооронд автотээврийн хэрэгслийг ашиглан ачаа тээвэрлэлтийн ажил, үйлчилгээ эрхэлж буй хуулийн этгээдэд итгэмжлэл олгох, ачааг тээвэрлэхтэй холбоотой тавигдах шаардлага, хүлээх эрх, үүргийг зохицуулахад оршино.

### ХОЁР. БИРЖИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1 Бирж дараах эрх, үүрэгтэй. Үүнд:
- 2.1.1. Итгэмжлэгдсэн тээвэрлэгч энэхүү гэрээний нөхцөлийг хангасан эсэхийг хууль, журамд заасан эрхийн хүрээнд шалгах;
  - 2.1.2. Итгэмжлэгдсэн тээвэрлэгчээс хуулиар нууцлаагүй баримт бичиг, мэдээллийг шаардлагатай тохиолдолд гаргуулах;
  - 2.1.3. Тээврийн хэрэгсэл, ачаа тээвэрлэлтийн нөхцөлийг сайжруулахыг шаардах;
  - 2.1.4. Итгэмжлэгдсэн тээвэрлэгчээр энэхүү гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах;
  - 2.1.5. Биржийн цахим системд шаардлагатай өөрчлөлт, шинэчлэлт явуулах;
  - 2.1.6. Олгосон итгэмжлэлийн хүрээнд Итгэмжлэгдсэн тээвэрлэгчид хариуцлага хүлээлгэх.
  - 2.1.7. Итгэмжлэлийн хүрээнд талуудын үйл ажиллагааны нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хангах;

- 2.1.8. Биржийн үйл ажиллагаатай холбоотой эрх бүхий байгууллагын аливаа шийдвэр, холбогдох мэдээллийг Биржийн албан ёсны эх сурвалж, эсвэл мэдээлэл солилцох сувгаар дамжуулан Итгэмжлэгдсэн тээвэрлэгчид мэдэгдэх.
- 2.1.9. Итгэмжлэгдсэн тээвэрлэгчийн үйл ажиллагаатай холбоотой Биржид ирүүлсэн аливаа, санал гомдол, хүсэлтийг холбогдох хууль, дүрэм журмын хүрээнд шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэхээр хүргүүлэх.

### **ГУРАВ. ИТГЭМЖЛЭГДСЭН ТЭЭВЭРЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 3.1. Итгэмжлэгдсэн тээвэрлэгч нь “Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам”-д зааснаас гадна дараах эрхтэй. Үүнд:
  - 3.1.1. Энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг биржээс шаардах;
  - 3.1.2. Итгэмжлэгдсэн тээвэрлэгчийн үйл ажиллагаатай холбоотой аливаа мэдээ, мэдээллийг цаг тухайд нь Биржээс авах, ;
  - 3.1.3. Бирж болон итгэмжлэгдсэн тээвэрлэгчийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй бичиг баримтад тайлбар хүсэх, өөрчлөлт оруулах хүсэлт гаргах;
  - 3.1.4. Биржийн итгэмжлэлээс татгалзах хүсэлт гаргах;
- 3.2. Итгэмжлэгдсэн тээвэрлэгч нь “Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам” болон “Тээвэрлэгчийн итгэмжлэл олгох журам”-д зааснаас гадна дараах үүрэгтэй. Үүнд:
  - 3.2.1. Монгол улсын холбогдох стандарт, тээвэрлэлтийн нөхцөл, итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах;
  - 3.2.2. Ачаа тээвэрлэхтэй холбоотой тээврийн хэрэгсэл, жолооч, цагийн хуваарь хүргэх барааны хэлцлийн дугаар зэрэг мэдээллийг тусгасан “Хүргэлт хийх мэдэгдэл”-ийг Биржид ирүүлэх;
  - 3.2.3. Тээвэрлэлт хийгдэхийн өмнө харилцагчтай “тээвэрлэлтийн гэрээ” байгуулж, чанд мөрдөж ажиллах;
  - 3.2.4. Хүргэлт хийх ачааны гарал үүсэл, өвчний эх үүсвэргүйг тодорхойлсон баримтыг ачих агуулахаас авах;
  - 3.2.5. Тээвэрлэж буй ачаанд болон тээвэрлэлтийн нөхцөлд аливаа өөрчлөлт орсон даруйд Биржид нэн даруй мэдэгдэх;
  - 3.2.6. Итгэмжлэл болон ачаа тээвэрлэлттэй холбоотой Биржийн холбогдох журам, заавар, зөвлөгөөг дагах,
  - 3.2.7. Энэхүү гэрээний 3.2.3-т заасан “Тээвэрлэлтийн гэрээ”-ний дагуу ачааг цаг хугацаанд нь хурдан шуурхай, бүрэн бүтэн тээвэрлэх;
  - 3.2.8. Ачааг хүлээн авах/хүлээлгэн өгөхдөө итгэмжлэгдсэн агуулахын бараа хүлээлцсэн баримтад үндэслэн хүлээн авах/хүлээлгэн өгөх;
  - 3.2.9. Ачааг хүлээн авахдаа сав, баглаа боодол, битүүмжилсэн лацны бүрэн бүтэн байдлыг шалгаж авах үүрэгтэй.
  - 3.2.10. Хэрэв битүүмжилсэн лац, сав баглаа боодол гэмтсэн тохиолдолд түүнээс үүдэн гарах хариуцлагыг тээвэрлэгч хүлээнэ.
  - 3.2.11. Бараа хүлээлцсэн баримт үйлдсэнээс хойш тээвэрлүүлэгч талын итгэмжлэгдсэн агуулахад хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд итгэмжлэгдсэн тээвэрлэгч нь тээвэрлэж буй ачааны чанар, тоо хэмжээ, бүрэн бүтэн байдлыг хариуцах үүрэгтэй. Агуулахаас ачааг хүлээн авснаас хойш хүргэлтийн явцад гарсан хохирлыг тээвэрлэгч тал хариуцна.

- 3.2.12. Итгэмжлэгдсэн тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааг алдагдуулалгүйгээр ачаа хүргэлтийн үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах үүрэгтэй.
- 3.2.13. Тээвэрлэгч нь хуулинд заасны дагуу тухайн тээврийн хэрэгсэл болон хүргэлт хийх ажилтныг даатгуулсан байх үүрэгтэй.
- 3.2.14. Ачааг хүргэх явцад ажилтан болон тээврийн хэрэгсэлд хохирол буюу гэмтэл учирсан тохиолдолд түүнийг бүрэн барагдуулах үүрэгтэй.
- 3.2.15. Тээвэрлэгч нь хүргэлт хийгдэж буй ачааг даатгалын компаниар даатгуулах үүрэгтэй.
- 3.2.16. Ажил үүргээ гүйцэтгэж яваа Биржийн ажилтан болон харилцагчдад түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх, үнэн зөв мэдээлэл өгөх;
- 3.2.17. Шалгалтаар яваа Биржийн ажилтныг ажиллах нөхцөл, боломжоор хангах;
- 3.2.18. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтын явцад илэрсэн зөрчлийг яаралтай арилгах арга хэмжээ авах;
- 3.2.19. Итгэмжлэлийг түдгэлзүүлсэн, цуцалсан тохиолдолд тээвэрлэлт хийгдэж буй ачаа, харилцагчид хохирол учруулах үйлдэл гаргахгүй байх.
- 3.2.20. Энэхүү гэрээний Хавсралт 2 буюу “Харилцагчтай байгуулан мөрдөх гэрээнд зайлшгүй тусгах жагсаалт”-ыг тээвэрлэлтийн гэрээнд тусгана.
- 3.2.21. Бирж болон тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой аливаа хүсэлт, санал гомдлыг албан бичгээр хүргүүлнэ.

## **ДӨРӨВ. ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА**

- 4.1 Талуудын аль нэг нь нөгөө талын зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээгээр хүлээсэн эрх үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэх, мөн гэрээ цуцлахыг хориглох бөгөөд энэ тухай мэдээллийг дор хаяж 1 сарын өмнө бичгээр мэдэгдэх үүрэгтэй.
- 4.2 Гэрээнд гарч буй төлбөр тооцоо, үнэ, тээвэрлэлтийн мэдээ зэрэг компаний нууцад хамаарах мэдээллийг гуравдагч этгээдэд задруулахгүй байх үүрэгтэй.
- 4.3 Талуудын аль нэг тал гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс гарсан хохирлыг буруутай тал нь бүрэн хариуцна. Хохирлыг барагдуулаагүй тохиолдолд хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.
- 4.4 Талууд гэрээний биелэлтийн талаар маргаантай асуудал гаргавал харилцан зөвшилцөн шийдвэрлэх бөгөөд тохиролцоонд хүрэхгүй тохиолдолд хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.
- 4.5 Тээвэрлэгч болон тээвэрлүүлэгч нь хохирол учирсан тухай мэдсэн даруй шалтгааныг тодорхойлох ба шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагад хандана.

## **Тав. БУСАД**

- 5.1. Гэрээ байгуулсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор Итгэмжлэгдсэн тээвэрлэгч Биржийн Захиргаа дотоод аудитын хэлтэст “Тээвэрлэгчийн итгэмжлэлийн төлбөр”-т 2,000,000 (хоёр сая) төгрөгийг төлнө. Тээвэрлэгчийн итгэмжлэлийн төлбөр төлөхгүй байх нь итгэмжлэлийг түдгэлзүүлэх үндэслэл болно.
- 5.2. Энэхүү Гэрээг \_\_\_\_ жилийн хугацаатайгаар байгуулна.
- 5.3. Энэхүү Гэрээний хавсралтууд нь тус гэрээний салшгүй хэсэг мөн.
- 5.4. Гэрээг 2 хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалах ба гэрээнд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр гэж үзнэ.

- 5.5. Гэрээний хугацаанд аль нэг тал Гэрээг цуцлах, нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргаагүй тохиолдолд Гэрээг Биржийн гүйцэтгэх удирдлагын шийдвэрээр сунгана.
- 5.6. Гэрээний нөхцөлүүд болон Биржийн аливаа журам, шийдвэрийг мэдээгүй, эсвэл ойлгоогүй нь хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 5.7. Гэрээнд заасан болон заагаагүй нөхцөл байдлаас үүдсэн аливаа маргааныг талууд хамтдаа хэлэлцэн тохиролцож шийдвэрлэх бөгөөд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд холбогдох хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

Хөдөө аж ахуйн биржийн Төлбөр  
тооцоо ложистикийн хэлтсийн  
захирал  
.....//

.....ХХК  
.....  
.....  
.....

**МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ СУВАГ**

**Хөдөө аж ахуйн биржийн хаяг:**

УБ-14210, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,  
Энхтайваны өргөн чөлөө 23, УВН center,  
14давхар

**Төлбөр тооцоо, Ложистикийн хэлтэс**  
**утас:70148779**

Хөдөө аж ахуйн биржийн цахим шуудан:

info@mce.mn

**Итгэмжлэгдсэн тээвэрлэгчийн хаяг:**

.....  
.....  
.....

**МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ СУВАГТ ӨӨРЧЛӨЛТ ОРСОН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ:**

.....  
.....  
.....  
  
.....  
.....  
.....

## **ХАРИЛЦАГЧТАЙ БАЙГУУЛАН МӨРДӨХ ГЭРЭЭНД ЗАЙЛШГҮЙ ТУСГАХ ЖАГСААЛТ**

**Итгэмжлэгдсэн тээвэрлэгч нь харилцагчтай байгуулах тээвэрлэлтийн гэрээнд дараах зүйлийг зайлшгүй тусгана. Үүнд:**

- Цагийн хуваарь, үйлчилгээний төлбөр, нөхцөл, тохирох;
- Ачааг итгэмжлэгдсэн тээврийн хэрэгслээр тээвэрлэхэд тухайн барааны ачилт, тээвэрлэлт, буулгалттай холбоотой барааг хүлээн авах, хүлээлгэн өгөх, чингэлгийг битүүмжилсэн лац, таних тэмдэг тавих үйл ажиллагаануудыг гэрээний аль тал хэрхэн гүйцэтгэх, хариуцлагын талаар тодорхой заах;
- Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ (даатгал г.м.);
- Харилцагчийн барааны баглаа боодол, хаяглалт нь шаардлага хангахгүй, стандартад илт нийцэхгүй тохиолдолд тухайн барааг хүлээн авахаас татгалзах;
- Биржийн бараа хүлээн авсныг баталгаажуулж, бараа хүлээн авсан баримтыг харилцагчид хэвлэн өгөх;
- Тээвэрлэлтийн явцад биржийн барааны чанар, тоо хэмжээ, хаяглалтын бүрэн бүтэн байдалд өөрчлөлт оруулахгүй байх;
- Тээвэрлэж буй бараанд болон хадгалалтын нөхцөлд аливаа өөрчлөлт орсон, бусад шалтгаанаар харилцагчид үүссэн хохирлыг барагдуулах;
- Итгэмжлэлийг түдгэлзүүлсэн, цуцалсан тохиолдолд тээвэрлэлт хийгдэж буй ачаа, харилцагчид хохирол учруулах үйлдэл гаргахгүй байх.

